

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН СПОРТЫН XI НААДАМ

Монгол Улсын Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1061 дүгээр захирамжаар Нийслэлийн Иргэдийн спортын XI наадмыг 2023 оны 07 дугаар сараас 12 дугаар сарын 03-ны хооронд спорт явган аялал, орс таталт, сагсан бөмбөг, волейбол, софт волейбол, хийн дасгал, аэробик, ширээний шагайн наадгай, дартс гэсэн спортын 9 төрлөөр 5 үе шат (хэсэг, хороо, бүс, дүүрэг, нийслэл)-тайгаар амжилттай зохион байгуулсан.

Энэхүү наадам нь багийн бүрэлдэхүүнд 31-ээс дээш настай нийслэлийн иргэн байх, тухайн төрлийн спортын дэд мастераас дээш цолтой тамирчин 45-аас дээш настай байх, наадмын нэг төрөлд нэг тамирчин орох, шалгарсан баг тамирчид үндсэн бүрэлдэхүүнээрээ шат шатны тэмцээнд оролцох зэрэг нь бие бялдрыг чийрэгжүүлэх, хөдөлгөөний хомсдлоос сэргийлэх, хүн амыг биеийн тамир, спортын уралдаан тэмцээнд өргөнөөр хамруулах, иргэдийн идэвх санаачлагыг өрнүүлэх, хөршийн холбоог сайжруулах зэрэг онцлог шинжтэй үйл ажиллагаа болсон.

Нийслэлийн Иргэдийн спортын XI наадамд нийт 9 дүүргийн 171 хорооны 90000 иргэн оролцсон.

Нийслэлийн шигшээ тэмцээнд 65 хорооны 124 багийн 1042 иргэн оролцлоо. Нийслэлийн Шигшээ тэмцээний нэгдсэн нээлтийн арга хэмжээг 2023 оны 11 дүгээр сарын 21-22-ны өдрүүдэд Баянгол дүүргийн Биеийн тамир, спортын спорт цогцолбор, Модун цамхаг спорт цогцолборт тус тус зохион байгуулсан.

Нээлтийн арга хэмжээг нээж Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын дарга Ж.Ганболд үг хэлж, Нийслэлийн 9 дүүргийн Биеийн тамир, спортын хороодын дарга нар оролцсон.



- Нийслэлийн Иргэдийн спортын XI наадмын шигшээ тэмцээнд оролцог байгаа Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спортын хорооны туг, Баянгол дүүргийн Биеийн тамир, спортын хорооны туг, Багахангай дүүргийн Биеийн тамир, спортын хорооны туг, Багануур дүүргийн Биеийн тамир, спортын хорооны туг, Налайх дүүргийн Биеийн тамир, спортын хорооны туг, Сүхбаатар дүүргийн Биеийн тамир, спортын хорооны туг, Сонгинохайрхан дүүргийн Биеийн тамир, спортын хорооны туг, Чингэлтэй дүүргийн Биеийн тамир, спортын хорооны туг, Хан-Уул дүүргийн Биеийн тамир, спортын хорооны тугийг Монголын Спорт сонирхогч, хөгжөөн дэмжигчдийн холбооны тамирчид залан орж ирсэн.
- Нээлт хаалтын хөтөлгөөр МҮОНРТ-ын спорт сувгийн сэтгүүлч Ж.Батжаргал ажилласан.
- Нийслэлийн иргэдийн спортын XI наадмын шигшээ тэмцээнд оролцогч тамирчдыг төлөөлж Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны иргэн, Ширээний шагайн наадгайн

дүүргийн 11 дэх удаагийн аварга, нийслэлийн 2 удаагийн аварга тамирчин Цэдэвсүрэнгийн Оюунчулуун тангараг өргөсөн.

- Нийслэлийн иргэдийн спортын XI наадмын шигшээ тэмцээнийг шүүн явуулах шүүгчдийг төлөөлж Нийслэлийн Иргэдийн спортын XI наадмын Волейболын тэмцээний шүүгч Мөнх-Очирын Очир-Эрдэнэ тангараг өргөсөн.
- Нээлтийн арга хэмжээнд Аэробик гимнастикийн үзүүлэх тоглолтыг Монголын спорт сонирхогчдын хөгжөөн дэмжигчдийн холбооны тамирчид хийж гүйцэтгэсэн.



НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН СПОРТЫН XI НААДМЫН ШИРЭЭНИЙ ШАГАЙН НААДГАЙН ШИГШЭЭ ТЭМЦЭЭН

Нийслэлийн Иргэдийн спортын XI наадмын ширээний шагайн наадгайн шигшээ тэмцээнийг 2023 оны 11 дүгээр сарын 17-18-ны өдрүүдэд Монголын спорт сонирхогчдын хөгжөөн дэмжигчдийн холбоо, Монголын ширээний шагайн холбоотой хамтран Чингэлтэй дүүргийн Биеийн тамир, спортын хорооны спорт цогцолборт зохион байгуулсан.



Ширээний шагайн наадгайн шигшээ тэмцээн нь морь уралдуулах, шагай шүүрэх, шагай няслах гэсэн 3 төрлөөр зохион байгуулж Нийслэлийн 9 дүүргээс шалгарсан 18 хорооны 18 багийн 252 тамирчид өрсөлдсөнөөс:

Шагналт байранд шалгарсан баг тамирчид:

Эмэгтэй:

1-р байр: Хан-Уул дүүргийн 14 дугаар хорооны баг

2-р байр: Багануур дүүргийн 5 дугаар хорооны баг

3-р байр: Налайх дүүргийн 5 дугаар хорооны баг

Эрэгтэй:

1-р байр:Налайх дүүргийн 5 дугаар хорооны баг

2-р байр:Багахангай дүүргийн 1 дүгээр хорооны баг

3-р байр:Сүхбаатар дүүргийн 19 дүгээр хорооны баг тус тус шалгарч алт, мөнгө, хүрэл медаль, өргөмжлөл, цом, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан.



Монголын спорт сонирхогчдын хөгжөөн дэмжигчдын холбооноос томилогдсон Ц.Тэгшжаргал, Т.Тэгштулга, С.Эрдэнэбат, Т.Далхаасүрэн, С.Тунгалаг, Т.Тэгш-Оч, Э.Анужин, А.Өсөхбаяр, Л.Оюун-Эрдэнэ, Ж.Даваадулам нар 10 хүний шүүгчдийн бүрэлдэхүүнтэй 2 өдөр ажилласан.

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН СПОРТЫН XI НААДМЫН АЭРОБИКИЙН ШИГШЭЭ ТЭМЦЭЭН



Нийслэлийн Иргэдийн спортын XI наадмын ширээний шагайн наадгайн шигшээ тэмцээнийг 2023 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр Монголын спорт сонирхогчдын хөгжөөн дэмжигчдийн холбоотой хамтран Баянгол дүүргийн Биеийн тамир, спортын хорооны спорт цогцолборт зохион байгуулсан.

Аэробикийн шигшээ тэмцээнд баг нь 31 ба түүнээс дээш насны 12 тамирчдын бүрэлдэхүүнтэй, Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас баталсан заавал хийх дасгалаар оролцсон.

Тэмцээнд 9 дүүргийн 9 багийн 108 тамирчид оролцлоо.

Монголын спорт сонирхогчдын хөгжөөн дэмжигчдийн холбооноос томилогдсон Э.Мөнх-Оргил, Р.Батсүрэн, Э.Ариунаа, С.Нэмэхбаяр нар шүүн явуулж, Ю.Мөнхтуяа,

Ч.Батбуян, М.Хонгорзул, Н.Хулан нар зохион байгуулагч шүүгчдээр тус тус 1 өдөр ажилласан.

Шагналт байранд шалгарсан баг тамирчид:

1-р байр:Налайх дүүргийн 2 дугаар хорооны баг

2-р байр:Баянгол дүүргийн 3 дугаар хорооны баг

3-р байр:Баянзүрх дүүргийн 36 дугаар хорооны баг тус тус шалгарч, алт, мөнгө, хүрэл медаль, өргөмлөл, цом, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан.



НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН СПОРТЫН XI НААДМЫН ХИЙН ДАСГАЛЫН ШИГШЭЭ ТЭМЦЭЭН

Нийслэлийн Иргэдийн спортын XI наадмын ширээний шагайн наадгайн шигшээ тэмцээнийг 2023 оны 11 дүгээр сарын 18-ны өдрүүдэд Монголын спорт сонирхогчдын хөгжөөн дэмжигчдийн холбоо, Монголын хийн дасгалын холбоотой хамтран Баянгол дүүргийн Биеийн тамир, спортын хорооны спорт цогцолборт зохион байгуулсан.



Баг нь 31-50 насны 4 тамирчин, 51 ба түүнээс дээш насны 8 тамирчин нийт 12 тамирчдын бүрэлдэхүүнтэй, Монголын Хийн дасгалын холбооноос боловсруулан гаргасан Бие чийрэгжүүлэх “Таван амьтан”-ны дасгалыг хийж гүйцэтгэсэн.

Шигшээ тэмцээнд 9 багийн 108 иргэд оролцсон.

Монголын спорт сонирхогчдын хөгжөөн дэмжигчдийн холбооноос томилогдсон шүүгчдийн бүрэлдэхүүн шүүн явуулсан.

Ерөнхий шүүгч:Х.Оюунбилэг,

Шүүгч:Ц.Март

Шүүгч:А.Болорцэцэг

Шүүгч:Ц.Оюунгэрэл

Шүүгч:Д.Нарангэрэл

Шүүгч:Д.Оюунгэрэл

Шүүгч:Ч.Чулуунцэцэг

Нарийн бичиг шүүгч:Б.Урангоо нар 8 хүний бүрэлдэхүүнтэй 1 өдөр ажилласан.

Шагналт байранд шалгарсан баг тамирчид:

1-р байр:Хан-Уул дүүргийн 8 дугаар хорооны баг

2-р байр:Сонгинохайрхан дүүргийн 14 дүгээр хорооны баг

3-р байр:Баянгол дүүргийн 6 дугаар хорооны баг тус тус шалгарч, алт, мөнгө, хүрэл медаль, өргөмлөл, цом, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан.



НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН СПОРТЫН XI НААДМЫН ОЛС ТАТАЛТЫН ШИГШЭЭ ТЭМЦЭЭН

Нийслэлийн Биеийн тамир, спортын газар, Монголын олс таталтын холбоотой хамтран Нийслэлийн Иргэдийн спортын XI наадмын Олс таталтын шигшээ тэмцээнийг 2023 оны 11 дүгээр сарын 19-20-ны өдрүүдэд “Аварга” дээд сургуулийн спорт зааланд, Модун цамхаг спорт цогцолборт тус тус зохион байгуулсан.

Нийслэлийн Биеийн тамир, спортын газар, Монголын Олс таталтын холбоо, Монголын Спорт сонирхогчдын хөгжөөн дэмжигчдийн холбоо хамтран тус тэмцээний техникийн зөвлөгөөнийг 2023 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 13:00-14:00 цагийн хооронд дүүргүүдийн Биеийн тамир, спортын хорооны мэргэжилтнүүд болон оролцох багуудын дасгалжуулагч, багийн ахлагч нарын дунд зохион байгуулсан.



Монголын олс таталтын холбооноос томилогдсон шүүгчдийн бүрэлдэхүүнд багтсан 10 шүүгчид эрэгтэй төрөлд 5, эмэгтэй төрөлд 5 шүүгч хуваарилагдан тэмцээний зам засах, олс тэмдэглэх, жин үзэх зэрэг бэлтгэл ажлуудыг хангаж тэмцээнийг шүүн явуулсан.

Үүнд: Эрэгтэй төрөлд шүүсэн шүүгчид:

Ерөнхий шүүгчээр М.Дорж

Нарийн бичиг шүүгчээр С.Жинчинхангай

Хажуугийн шүүгчээр А.Баасандорж, Б.Энхбат

Эмч шүүгчээр Б.Бүжинлхам нар ажиллаа.

Эмэгтэй төрөлд шүүсэн шүүгчид:

Ерөнхий шүүгчээр Б.Эрдэнэчимэд

Нарийн бичиг шүүгчээр Г.Төгөлдөр

Хажуугийн шүүгчээр Б.Батзориг, Г.Үнэнхүү

Тайлбарлагч шүүгчээр У.Жалбадорж нар ажиллаа.

Нийслэлийн шигшээ шатанд нийт 8 дүүрэг (Баянгол, Баянзүрх, Багануур, Сонгинохайрхан, Сүхбаатар, Налайх, Чингэлтэй, Хан-Уул)-ээс шалгарч ирсэн эрэгтэй, эмэгтэй тус бүр 8 баг 9 тамирчин, нэг дасгалжуулагчийн бүрэлдэхүүнтэй нийт 144 тамирчид өрсөлдлөө.



Шагалт байранд шалгарсан баг тамирчид:

Эмэгтэй

- 1-р байр:Багануур дүүргийн 1 дүгээр хорооны баг
- 2-р байр:Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хорооны баг
- 3-р байр:Хан-Уул дүүргийн 21 дүгээр хорооны баг

Эрэгтэй

- 1-р байр:Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хорооны баг
- 2-р байр:Багануур дүүргийн 1 дүгээр хорооны баг
- 3-р байр:Хан-Уул дүүргийн 21 дүгээр хорооны баг тус тус шалгарч, алт, мөнгө, хүрэл медаль, өргөмлөл, цом, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан.



НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН СПОРТЫН XI НААДМЫН САГСАН БӨМБӨГИЙН ШИГШЭЭ ТЭМЦЭЭН

Нийслэлийн иргэдийн спортын XI наадмын сагсан бөмбөгийн шигшээ тэмцээний урьдчилан тоглолтыг 2023 оны 11 дүгээр сарын 21-24-ний өдрүүдэд Баянгол дүүргийн Биеийн тамир, спортын хорооны спорт цогцолборт, Модун цамхаг спорт цогцолборт тус тус Монголын спорт сонирхогчдын хөгжөөн дэмжигчдийн холбоо, Сагсан бөмбөгийн шүүгчидтэй хамтран зохион байгуулсан.



Шигшээ тэмцээнд Нийслэлийн 9 дүүргээс шалгарсан 18 хорооны 18 багийн 234 тамирчид оролцсон.

Монголын спорт сонирхогчдын хөгжөөн дэмжигчдын холбооноос томилогдсон шүүгчдийн бүрэлдэхүүн шүүн явуулсан.

Ерөнхий шүүгч: Н.Энхтуул,

Шүүгч: Г.Батбаатар

Шүүгч: Г.Манлайбаатар

Шүүгч: П.Цэцэгсүрэн

Шүүгч: О.Отгон

Шүүгч: Ж.Мөнхнамжил

Шүүгч: Б.Мөнхтоогоо

Шүүгч: Э.Оюун-Эрдэнэ

Шүүгч: Э.Отгонбаатар

Шүүгч: Г.Санчирмаа

Шүүгч: Б.Лхагвацэцэг

Шүүгч: С.Бямбазаяа

Шүүгч: А.Солонго

Шүүгч: Б.Дэлгэрмөрөн

Шүүгч: Г.Батсуурь нар 15 хүний бүрэлдэхүүнтэй 4 өдөр ажилласан.

Шагналт байранд шалгарсан баг тамирчид:

Сагсан бөмбөгийн тэмцээн (эмэгтэй)

1-р байр: Хан-Уул дүүргийн 3 дугаар хорооны баг

2-р байр: Налайх дүүргийн 8 дугаар хорооны баг

3-р байр: Багануур дүүргийн 1 дүгээр хорооны баг

Сагсан бөмбөгийн тэмцээн (эрэгтэй)

1-р байр: Хан-Уул дүүргийн 10 дугаар хорооны баг

2-р байр: Баянгол дүүргийн 26 дугаар хорооны баг

3-р байр: Баянзүрх дүүргийн 42 дугаар хорооны баг тус тус шалгарч, алт, мөнгө, хүрэл медаль, өргөмлөл, цом, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан.



НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН СПОРТЫН XI НААДМЫН СОФТ ВОЛЕЙБОЛЫН ШИГШЭЭ ТЭМЦЭЭН



Нийслэлийн Иргэдийн спортын XI наадмын софт волейболын шигшээ тэмцээнийг 2023 оны 11 дүгээр сарын 23-24-ний өдрүүдэд Хан-Уул дүүргийн Биеийн тамир, спортын хорооны спорт зааланд зохион байгуулсан.

Тэмцээнд 9 багийн 54 тамирчид оролцсон.

Софт волейболын тэмцээнд шагналт байранд шалгарсан баг, тамирчид:

1-р байр: Сүхбаатар дүүргийн 13 дугаар хорооны баг

2-р байр: Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хорооны баг

3-р байр: Баянгол дүүргийн 26 дугаар хорооны баг тус тус шалгарч, алт, мөнгө, хүрэл медаль, өргөмлөл, цом, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан.



НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН СПОРТЫН XI НААДМЫН ДАРТСЫН ШИГШЭЭ ТЭМЦЭЭН

Нийслэлийн Иргэдийн спортын XI наадмын Дартсын шигшээ тэмцээнийг 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдрүүдэд Чингэлтэй дүүргийн Биеийн тамир, спортын хорооны спорт зааланд Монголын спорт сонирхогчдын хөгжөөн дэмжигчдийн холбоо, Монголын дартс сонирхогчдын холбоотой хамтран зохион байгуулсан.



Дартсын шигшээ тэмцээнийг эмэгтэй дан хос, эрэгтэй дан хос, баг гэсэн 3 төрлөөр зохион байгуулж, нийт 9 дүүргийн 27 багийн 108 тамирчид оролцсон.

Дартсын тэмцээнд шагналт байранд шалгарсан баг, тамирчид:

Эмэгтэй хос

1-р байр: Баянзүрх дүүргийн 7 дугаар хорооны баг,

2-р байр: Баянгол дүүргийн 1 дүгээр хорооны баг,

3-р байр: Сонгинохайрхан дүүргийн 15 дугаар хорооны баг

Эрэгтэй хос

1-р байр: Багануур дүүргийн 3 дугаар хорооны баг,

2-р байр: Баянзүрх дүүргийн 13 дугаар хорооны баг,

3-р байр: Сүхбаатар дүүргийн 12 дугаар хорооны баг

Багийн төрөл

1-р байр: Хан-Уул дүүргийн 15 дугаар хорооны баг,

2-р байр: Чингэлтэй дүүргийн 18 дугаар хорооны баг,

3-р байр:Багануур дүүргийн 1 дүгээр хорооны баг тус тус шалгарч, алт, мөнгө, хүрэл медаль, өргөмлөл, цом, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан.



НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН СПОРТЫН XI НААДМЫН ВОЛЕЙБОЛЫН ШИГШЭЭ ТЭМЦЭЭН

Нийслэлийн Иргэдийн спортын XI наадмын волейболын шигшээ тэмцээнийг 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 03-ны өдрүүдэд Баянгол дүүргийн Биеийн тамир, спортын хорооны спорт цогцолборт, Модун цамхаг спорт цогцолборт тус тус зохион байгуулсан.



Шигшээ тэмцээнд 9 дүүргийн 18 багийн 162 иргэд оролцсон.

Волейболын тэмцээн (эмэгтэй)

1-р байр:Налайх дүүргийн 5 дугаар хорооны баг

2-р байр:Баянгол дүүргийн 6 дугаар хорооны баг

3-р байр:Сонгинохайрхан дүүргийн 1 дүгээр хорооны баг

Волейболын тэмцээн (эрэгтэй)

1-р байр:Сүхбаатар дүүргийн 14-р хорооны баг

2-р байр:Налайх дүүргийн 8 дугаар хорооны баг

3-р байр:Багануур дүүргийн 1 дүгээр хорооны баг тус тус шалгарч, алт, мөнгө, хүрэл медаль, өргөмлөл, цом, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан.



НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН СПОРТЫН XI НААДМЫН СПОРТ ЯВГАН АЯЛАЛЫН ШИГШЭЭ ТЭМЦЭЭН



Нийслэлийн Иргэдийн спортын XI наадмын спорт явган аялалын шигшээ тэмцээнийг Нийслэлийн Иргэдийн спортын XI наадмын спорт явган аялалын шигшээ тэмцээнийг 2023 оны 09 дүгээр сарын 16-17-ны өдрүүдэд “Улаанбаатар-Үндэсний цэцэрлэгт хүрээлэн-Чулуутын ам-Чулуутын гол-Чулуутын ам-Улаанбаатар” чиглэлд автомашинаар 42км, явган алхалтаар 10км туулж зохион байгуулсан.

Нийслэлийн шигшээ тэмцээнд 9 дүүргийн 9 багийн 54 тамирчид оролцсон.

Шагналт байранд шалгарсан багуудын шагналыг 2023 оны 12 дугаар сарын 03-ны өдөр наадмын нэгдсэн хаалтын арга хэмжээний үеэр гардуулан өгсөн.

Тэмцээний нэгдсэн дүнгээр:

1-р байр:Налайх дүүргийн 5-р хороо

2-р байр:Хан-Уул дүүргийн 21-р хороо

3-р байр:Баянзүрх дүүргийн 41-р хороо тус тус шалгарч, алт, мөнгө, хүрэл медаль, өргөмлөл, цом, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан.

ШИЛДЭГ ХОРООД:

- 1.Чингэлтэй дүүргийн 16 дугаар хороо;
- 2.Хан-Уул дүүргийн 21 дүгээр хороо;
- 3.Баянзүрх дүүргийн 41 дүгээр хороо;
- 4.Налайх дүүргийн 8 дугаар хороо;

5. Сонгинохайрхан дүүргийн 3 дугаар хороо;
6. Сүхбаатар дүүргийн 16 дугаар хороо;
7. Багануур дүүргийн 1 дүгээр хороо
8. Баянгол дүүргийн 2 дугаар хороо
9. Багахангай дүүргийн 1 дүгээр хороо тус тус шалгарч өргөмжлөл, цом, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан.



НИЙСЛЭЛИЙН ШИГШЭЭ ТЭМЦЭЭНД НИЙЛБЭР ДҮНГЭЭР:

ТЭРГҮҮН БАЙРАНД: Т.Уранчимэг даргатай Хан-Уул дүүргийн Биеийн тамир, спортын хороо

ДЭД БАЙРАНД: Д.Мөнхбаяр даргатай Налайх дүүргийн Биеийн тамир, спортын хороо

ГУТГААР БАЙРАНД: Б.Мөнх-Эрдэнэ даргатай Сүхбаатар дүүргийн Биеийн тамир, спортын хороо тус тус шалгарч өргөмжлөл, цом, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан.

